



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ТӨРИЙН АУДИТЫН ТАЛААР ТӨРӨӨС  
БАРИМТЛАХ БОДЛОГЫН БАРИМТ  
БИЧГИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫН  
УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН  
СУДАЛГАА

2018 он

АГУУЛГА

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ .....	3
ХОЁР. АСУУДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ.....	4
ГУРАВ. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОМЬЁОЛОХ .....	6
ДӨРӨВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛЫН ХАРЬЦУУЛАЛТ .....	7
ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ .....	9
ЗУРГАА. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ.....	10
ДОЛОО. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ .....	12
НАЙМ. ЗӨВЛӨМЖ .....	20
ТОВЧИЛСОН ҮГ .....	22

## НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсад аудитын тогтолцоо үүсч, хөгжлийн 20 гаруй жилийг өнгөрүүлээд байгаа бөгөөд өнөөгийн байдлаар төрийн, хувийн хэвшлийн аудитын хуулийн этгээд, дотоод аудит гэсэн үндсэн гурван чиглэл тулхүү хөгжиж, олон улсын нийтлэг чиг хандлага, жишгийн дагуу өөр өөрсдийн хууль, эрх зүй, стандарт, арга аргачлалын дагуу үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

Төрийн аудитын байгууллага бүх аймгуудад удирдлагын босоо тогтолцоо бүхий 22 салбар байгууллага, нийт 389 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.

Төрийн аудитын тогтолцоо, төрийн аудитыг хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, үйл ажиллагааны эрх зүйн үндэс хийгээд төрийн аудитыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлж, зохицуулсан.

Үндэсний аудитын газар нь Монгол Улсын Аудитын дээд байгууллага бөгөөд санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийхээр хуульчлагдсан.

Төрийн өмч, хөрөнгийг зөв зохистой, үр ашигтай ашиглах, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулах, төрийн байгууллага, олон нийтэд үнэн зөв, бодитой тайланг хүргэх нь улс орны хөгжил, нийгмийн тэгш байдал, хүртээмжтэй өсөлтөд чухал ач холбогдолтой билээ.

Дээрх зорилтыг нийгмийн нэгдмэл байдлыг хамгаалж, төрийн цэвэр тунгалаг байдлыг тодорхойлдог, хараат бус байдлыг нь Үндсэн хуулиар баталгаажуулсан Төрийн аудитын байгууллага /ТАБ/-ын оролцоогүйгээр хангах боломжгүй юм.

Төрийн Аудитын тухай хууль 2003 онд батлагдан төрийн аудитын эрх зүйн орчин тодорхой хэмжээгээр бүрдсэн ч төрийн аудитын талаар төрөөс баримтлах бодлого нэгдсэн байдлаар томьёологоогүй байгаа нь төрийн аудитын тогтолцоо зөв зохистой ажиллахгүй, үйл ажиллагааны нэгдмэл байдал нь хангагдахгүй, улмаар бодлого, чиглэл тодорхойгүй байхад нөлөөлж байна.

Түүнчлэн ТАБ-ын чадавхыг сайжруулж, олон улсын аудитын чиг хандлагад нийцүүлэх, иргэддээ үйлчилдэг, хүний эрх, эрх чөлөөг хангадаг, авлига, хүнд суртлаас ангид ардчилсан төрийн тогтолцоог төлөвшүүлэх замаар төрийн институцийн хөгжлийг хангах асуудал чухлаар тавигдах боллоо.

Төрийн аудитын байгууллага 2017 онд санхүүгийн тайлангийн 3,179, гүйцэтгэлийн 210, нийцлийн 167, нийтдээ 3,556 аудит хийжээ<sup>1</sup>. 2017 оны аудитаар 11,477.9 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлж, 22.4 тэрбум төгрөгийн акт тогтоож, 2,537.9 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага, 7,694 зөвлөмж өгч, зөрчил гаргасан 447 албан тушаалтанд хариуцлага тооцуулан, 87 албан тушаалтны асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн.

2017 онд улсын хэмжээнд санхүүгийн тайлангийн аудитад хамрагдвал зохих 6,213 байгууллагын 3,179-д нь дүгнэлт гаргаж, аудитад хамрагдвал зохих нийт тайлангийн 51.2 хувьд аудит хийсэн байна. Үүнээс 2,116 аудитыг төрийн аудитын

<sup>1</sup> Төрийн аудитын байгууллагын 2017 оны статистик мэдээний урьдчилсан дүн

байгууллага, 1,063-ыг хувийн хэвшлийн аудитын хуулийн этгээдээр гэрээний үндсэн дээр гүйцэтгэсэн байна.

ТАБ нь төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөл хөтөлбөрийн санхүүгийн тайланд хийх хуулиар хүлээсэн цаглабарт хугацаатай нийт аудитын 17.0 хувийг хараат бус аудитын хуулийн этгээдээр гэрээгээр хийлгүүлжээ.

Төрийн аудитын зөвлөмжийн мөрөөр арга хэмжээ авч, зөрчлийг арилгуулах үр дүнтэй механизм хараахан бүрдээгүй байна.

ТАБ-ын нөөц хязгаарлагдмал байгаа нь байгууллагын чадавхад сөргөөр нөлөөлж байна. Тиймээс хуульд заагдсан бүрэн эрх хийгээд гүйцэтгэх ажил үүрэгтэй нь уялдуулан ТАБ-ын нөөцийг тогтоох нь зүйтэй.

ТАБ ажил үүргээ гүйцэтгэхэд өнөөгийн статус, хуулиар тогтоосон эрх мэдэл хангалтгүй байгаа бөгөөд хуулиар нэмж тогтоох бүрэн эрхийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд ТАБ-ын статусыг Үндсэн хуулийн байгууллага болгож нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

ИНТОСАИ-н стандартын зөвлөлөөс баталсан аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллагын стандартыг Монгол Улсад нутагшуулах, дэлхийн бусад орны аудитын дээд байгууллагуудын туршлагаас судалж, техникийн туслалцаа, зөвлөгөө авдаг давуу талаа бүрэн дүүрэн ашиглах боломж байна.

## ХОЁР. АСУУДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Төрийн Аудитын тухай хуульд ТАБ-ийн бүрэн эрхийг “төрийн байгууллага, төрийн өмчит аж ахуйн нэгж, төсвөөс санхүүжилт авсан байгууллагын үйл ажиллагаа хийгээд олон улсын байгууллага, гадаад орны санхүүжилтээр ажилладаг байгууллага, аж ахуйн нэгж, төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагаанд тэдний хүсэлтээр аудит хийх, Засгийн газрын тусгай зориулалтын сан, төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, эргэж төлөгдөх нөхцөлөөр ашиглуулж байгаа төсвийн хөрөнгө болон олон улсын байгууллага, гадаад орны Засгийн газар, байгууллага, иргэдээс Монгол Улсын Засгийн газар, төсвийн байгууллагад олгосон зээл, тусламж, хандивын ашиглалт, зарцуулалт, үр дүн болон улсын төсвийн хөрөнгө оруулалтад аудит хийж, үр дүнг нь төр засаг, ард түмэнд мэдээлэн тайлагнах явдал” гэж тодорхойлжээ.

ТАБ-ын алсын хараа нь: “ТАБ нь төрийн бодлого, шийдвэрийн үр дүн, үр нөлөөг сайжруулахад туслан, Монгол Улсын хөгжил дэвшилд дэмжлэг үзүүлж, иргэд, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөж, үнэлэгдэхийг эрмэлзэнэ.”

ТАБ-ын эрхэм зорилго нь “Улсын Их Хурал хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх болон төсвийн хөрөнгийн арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх” явдал юм.

Төрийн аудитын тухайн хуулийн З дугаар зүйлд Төрийн аудитын үндсэн зарчимд зааснаар Төрийн аудит нь хууль дээдлэх, шударга ёсыг хангах, ил тод, бодитой байх, төрийн аудитын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандартад нийцсэн байна.

ТАБ-ын стратегид эрхэмлэх үндсэн зарчмууд нь “ТАБ болон түүний ажилтнууд найдвартай- шударга- бодитой байх зарчмыг эрхэмлэн дээдэлж, Төрийн аудитын

төв байгууллагын үйл ажиллагаа, түүний үр дүн хамгийн найдвартай, аливаа нелөөнд автаагүй, үнэн, бодитой бөгөөд мэргэжлийн өндөр түвшинд явагдах ёстай” гэжээ.

Тиймээс дээрх зарчмуудын зөрүүтэй байдлыг нэгтгэж хуулийн Төрийн аудитын үндсэн зарчимд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

ТАБ нь аудит хийх байгууллагаа сонгодог, бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах аливаа мэдээллийг бүрэн хэмжээгээр, чөлөөтэй, шуурхай, үнэ төлбөргүй гаргуулж авах, бүтэц, орон тоогоо өөрөө батлах, өөрийн ажлын зохион байгуулалт, үйл ажиллагааны асуудлаар стандарт, дүрэм, журам, заавар батлах, гадны шинжээч, мэргэжилтнийг аудитын үйл ажиллагаанд татан оролцуулах эрхтэй.

Санхүүжилтийн эх үүсвэрээс хамаарахгүйгээр төрийн бүх байгууллагад бүхий л төрлийн аудит хийх бүрэн эрх бүхий статустай тус байгууллагын институцийн тогтолцоо хэвийн түвшинд байна.

Олон Улсын Төсвийн Түншлэл (International Budget Partnership) байгууллагаас жил бүр гаргадаг Нээлттэй төсвийн 2017 судалгаанд Төсвийн ил тод байдал (Budget Transparency), Төсвийн оролцоо (Budget Participation), Төсвийн хяналт (Budget Oversight) нийтийн хөрөнгө хэрхэн бий болж, зарцуулагдаж байгаа, Аудитын дээд байгууллагын бүрэн эрх, чадавх зэрэг үзүүлэлтээр дүн гаргасан ба төсвийн хяналт хэсэгт Монгол Улсын аудитын дээд байгууллага төсөвт тавих хяналт 100-аас 89 ондоо буюу ХАНГАЛТТАЙ ба хуульд зааснаар аудитыг боломжтой гэж үзсэн хэмжээнд явуулсан гэжээ.

2016 оны 12 дугаар сард ИНТОСАИ-ийн Аудитын дээд байгууллагын гүйцэтгэлийн хэмжүүрийн үзэл баримтлалыг ашиглан Монгол Улсын Үндэсний Аудитын Газрын санхүүгийн аудит болон бусад үйл ажиллагаанд хийсэн олон улсын түншийн үнэлгээний багийн тайланд “Монгол Улсын ҮАГ маш хүнд орчинд ажиллаж байна. Байгууллагын бүрэн эрх өргөн хүрээг хамарсан боловч үүнийг хэрэгжүүлэх нөөц маш хязгаарлагдмал байна. ҮАГ хүний нөөцийн хувьд ч, төсвийн хуваарилалтын хувьд ч хязгаарлагдмал байна. Иймээс ҮАГ нэн тэргүүнд гүйцэтгэх аудит болон аудит хийхгүй байгууллагуудыг тодорхойлдог эцсийн дүнд ҮАГ бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд байгаа нөөц нь хүрэлцдэггүй” гэсэн байна.

“Монгол Улсын ҮАГ-ын талаар Үндсэн хуулийн заалт байхгүй нь тухайн байгууллагыг 1992-1995 онд татан буулгаж байсан шиг нөхцөл байдал үүсэх магадлалтай. Төрийн аудитын тухай хууль нь ҮАГ-ын гол хууль эрх зүйн суурь баримт бичиг юм. Энэ хууль нь өргөн хүрээг хамарсан боловч Үндсэн хуулийн заалттай ижил байр суурьтай биш” гэжээ.

Цаашлаад аудитын дээд байгууллагын даргыг хууль тогтоох засаглалын зөвшөөрөлгүйгээр сольж болохгүй байгаа нь хараат бус байдлыг баталгаажуулж байна. Аудитын дээд байгууллага өөрийн мандатыг гүйцэтгэхэд хангалттай хэмжээний эх үүсвэртэй ба чанарын баталгаажуулалтын систем хязгаарлагдмал байна” гэж дүгнэв<sup>2</sup>.

Олон улсын аудитын үндсэн зарчмуудыг баталсан 1977 оны Лимагийн тунхаглалд аудитын дээд байгууллагыг байгуулах, түүний хараат бус байдлыг Үндсэн хуульд тусгаж өгөхөөр заасан байдаг ба энэ шаардлагыг хангаагүй Аудитын

<sup>2</sup>OBS2015-CS-Mongolia-English. 2016

дээд байгууллагыг үйл ажиллагааны чанар, үр дүнгээс үл хамааран стандартад нийцэхгүй гэж үздэг.

Гэтэл Лимагийн тунхаглалд заасан аудитын дээд байгууллагыг байгуулах, түүний хараат бус байдлыг Үндсэн хуулинд тусгах тулгуур зарчмыг Монгол Улс олон жил орхигдуулсаар иржээ.

Тиймээс Монгол Улсын Үндсэн хуульд нийтийн санхүүг хянах, төрийн санхүүгийн сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, ТАБ-ын чиг үүргийг тодорхойлсон заалт оруулах шаардлагатай байна.

Монгол Улсад өнөөгийн байдлаар 137 тусгай зөвшөөрөл бүхий хараат бус аудитын хуулийн этгээд үйл ажиллагаа явуулж байгаа ба хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн тайлангийн аудитын чиглэлээр зөвлөгөө өгөх, баталгаажуулах ажлыг голлон гүйцэтгэж байна.

Засгийн газрын яам, тэдгээрийн харьяа байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгжүүдэд 600 гаруй дотоод аудитор ажиллаж гүйцэтгэх засаглалын дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Мөн түүнчлэн байгаль орчны, мэдээллийн технологи зэрэг бусад салбарт аудит хөгжих эхлээд байна. 2012 онд Байгаль орчны багц хууль батлагдаж, байгаль орчны аудит хийх эрх зүйн үндэс бий болж, байгалийн нөөц ашиглаж буй аж ахуйн нэгжүүд хоёр жилд нэг удаа энэ чиглэлийн аудитыг заавал хийлгэдэг байхаар заажээ. Одоогийн байдлаар Монголд байгаль орчны аудитын чиглэлээр 29 компани үйл ажиллагаа явуулдаг ч өнөөг хүртэл ердөө 36 аудит хийгдсэн байна.

Ерөнхийд нь авч үзвэл Байгаль орчны аудитын үндсэн гурван төрөл байдаг бөгөөд үүнд байгаль орчны хуулийн хэрэгжилтийн аудит буюу нийцлийн аудит, хоёрт байгаль орчны менежментийн системийн аудит, гуравт гүйцэтгэл, үйл ажиллагааны аудит орно. Канад, АНУ зэрэг хөгжингүй улс орны хувьд байгаль орчны аудит гэх ойлголт нь 1980-аад оны эхээр үүссэн байна. Улс орнуудын хувьд байгаль орчны аудит хийхийг сайн дураар эсвэл хуулиар заавал дагаж мөрдөхөөр тусгасан байдгаараа ялгаатай байдаг. Манай улсын хувьд хуулиар дагаж мөрдөхөөр баталсан ч эдүгээ хуулийн хэрэгжилт хангалтгүй түвшинд байна.

Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого 2017 онд батлагдсан бөгөөд баримт бичгийн 2.3.8 дахь зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 3.9.7-д “Мэдээллийн технологийн аудитын тогтолцоог бүрдүүлнэ” гэж тусгаж өгсөн нь цаашид энэ чиглэлийн аудит хөгжих үндэс суурийг тавьж өгсөн байна.

Иймд төрийн аудитын бодлого, чиглэлтэй аудитын хуулийн этгээдийн тогтолцоо, дотоод аудит болон байгаль орчны, мэдээллийн технологийн зэрэг бусад салбарын аудитын үйл ажиллагааг уялдуулж, хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.

## ГУРАВ. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОМЬЁОЛОХ

“Төрийн аудитын талаар төрөөс баримтлах бодлого /цаашид “Бодлого” гэх/-ын зорилго нь харилцагч талуудын хамтын ажиллагааг өргөжүүлж, иргэдийн оролцоог хангах, чанарын хяналтын тогтолцоог бэхжүүлж, зөвлөн туслах замаар сайн засаглалыг дэмжсэн, олон улсын жишигт нийцсэн, нийгэм, эдийн засгийн бүхий л салбарыг хамарсан, чанартай, үр өгөөжтэй аудитыг гүйцэтгэн хүмүүнлэг, иргэний

ардчилсан нийгэм бүхий Монгол Улсын тогтвортой хөгжлийг хангахад төрийн аудитыг тэргүүлэх салбар болгон хөгжүүлэхэд оршино." гэсэн агуулгын хүрээнд бодлогын баримт бичгийн зорилгыг тодорхойлсон.

## **ДӨРӨВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛЫН ХАРЬЦУУЛАЛТ**

### **4.1. "Тэг" хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах**

Төрөөс төрийн аудитын талаар баримтлах дунд хугацааны бодлогын баримт бичиггүй байх нь Төрийн аудитын байгууллагын хараат бус байдал, эрх зүйн орчин, удирдлага, зохион байгуулалт, бүтцийг боловсронгуй болгох, түүнийг төгелдөржүүлэх, боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх болон аудитад иргэд олон нийтийн оролцоог хангах, харилцагч талуудтай харилцах харилцааг нэгдсэн бодлого удирдлагаар хангахад хүндэрэл бэрхшээл учрах бөгөөд Үндсэн хууль болон Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэх шаардлага байна.

### **4.2. Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх**

Төрийн аудитын байгууллагын бие даасан, хараат бус байдлыг нэмэгдүүлэх, эрх зүйн орчинг сайжруулах, олон улсын жишигт нийцүүлэх зэрэг шаардлагад хүрэхэд дан ганц хэвлэл мэдээллийн болон бусад хэрэгслээр олон нийтэд хандсан ухуулга сурталчилгааны ажил хийх нь хангалтгүй бөгөөд эрх зүйн зохицуулалт тодорхойгүй буюу хангалттай бус байх тохиолдолд үр нөлөөгүй гэж үзэж байна.

### **4.3. Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх**

Асуудал нь татвар, хураамжтай холбоогүй, зөвшөөрөл лиценз болон квотоос үл хамаарсан, хуулийн зохицуулалтаас үүдэлтэй тул энэхүү хувилбарыг хэрэгжүүлэх боломжгүй, үр дүн гарахгүй юм.

### **4.4. Төрөөс санхүүгийн интервенц хийх**

Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн орчныг сайжруулах, хараат бус байдлыг нэмэгдүүлэх, олон улсын жишигт нийцүүлэхтэй холбоогүй хуулийн зохицуулалттай холбоотой бүтцийн шинжтэй асуудал тул энэ хувилбарыг хэрэгжүүлэх боломжгүй болно.

### **4.5. Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх**

Төрийн аудитын байгууллага нь санхүүгийн тайланд аудит хийх чиг үүргээ аудитын бусад байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхээр Төрийн аудитын тухай хуулиар заасан бөгөөд аудитад хамрагдах нийт байгууллагын 17 хувийг хараат бус хувийн аудитын хуулийн этгээдээр гүйцэтгүүлж байна.

Төрийн аудитын байгууллага нь санхүүгийн тайлангийн аудитаас гадна гүйцэтгэлийн, нийцлийн аудит хийж байгаа ба эдгээр аудитыг гэрээний үндсэн дээр бусдаар гүйцэтгүүлэх хууль эрх зүйн боломжгүй тул энэхүү хувилбар нь асуудлыг бүрэн шийдвэрлэж, зорилгод хүргэх боломжгүй байна.

### **4.6. Захиргааны шийдвэр гаргах**

Төрийн аудитын байгууллагын бие даасан, хараат бус байдал, аудитын үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт Үндэсний аудитын газраас УИХ болон бусад этгээдтэй харилцах харилцаа нь зөвхөн хуулиар тодорхойлогдож зохицуулагддаг бөгөөд "захиргааны шийдвэр" буюу Захиргааны ерөнхий хуульд заасан нэг удаагийн эсвэл олон удаагийн тохиолдлыг зохицуулах шинжтэй захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт, захиргааны гэрээгээр уг асуудал шийдвэрлэгдэх боломжгүй юм. Иймд хуулиар шууд зохицуулсан харилцааг захиргааны шийдвэр гаргаж "өөрөөр зохицуулах" боломжгүй тул энэ хувилбарыг хэрэгжихгүй, үр дүнгүй гэж үзлээ.

#### 4.7. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах

Төрийн аудитын талаар төрөөс баримтлах урт хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулж УИХ-аар батлуулах, улмаар Төрийн аудитын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, үүнтэй уялдуулан төрийн аудитын үйл ажиллагаатай холбоотой холбогдох бусад хуулийн заалтуудад өөрчлөлт оруулах шаардлага тулгарч байна.

Төрийн аудитын талаар төрөөс баримтлах бодлогын зорилго нь ТАБ-ыг бэхжүүлэх, төр, засгийн газрын байгууллага, олон нийтийн оролцоог хангах замаар улс орны эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад оршино.

ТАБ-ын эрх зүйн орчин, удирдлага, зохион байгуулалт, бүтцийг боловсронгуй болгох, тэдгээрийг төгөлдөржүүлэх, боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхэд Төрийн аудитын талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг суурь нь болно.

Асуудлыг шийдвэрлэх хувилбаруудыг харьцуулж тоймлон үзвэл:

Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
Тэг хувилбар	Төрийн аудитын байгууллагын хараат бус байдал, эрх зүйн орчин, удирдлага, зохион байгуулалт, бүтцийг боловсронгуй болгох, түүнийг төгөлдөржүүлэх, боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх болон аудитад иргэд олон нийтийн оролцоог хангах, харилцагч талуудтай харилцах харилцааг нэгдсэн бодлого удирдлагаар хангахад хүндрэл бэрхшээл учирна.	Зардал бага хэмжээнд гарах боловч үр ашиг муутай.	Үр дүнгүй
Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Төрийн аудитын байгууллагын бие даасан, хараат бус байдлыг нэмэгдүүлэх, эрх зүйн орчинг сайжруулах, олон улсын жишигт нийцүүлэх зэрэг шаардлагад хүрэхэд дан ганц хэвлэл мэдээллийн болон бусад хэрэгслээр олон нийтэд	Хэвлэл мэдээлэл, олон нийтэд таниулах зорилготой холбоотой сургалт, нэвтрүүлэг, ухуулаг хийх нэмэлт зардал гарах боловч энэ	Үр дүнгүй

	хандсан ухуулга сурталчилгааны ажил хийх нь хангалтгүй	талаар хийгдэж буй арга хэмжээ зэрэг үр дагаврыг шууд богино хугацаанд үүсгэхгүй.	
Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх	Холбоогүй асуудал тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
Төрөөс санхүүгийн интервенц хийх	Холбоогүй асуудал тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	Асуудлыг бүрэн шийдвэрлэж, зорилгод хүрэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
Захиргааны шийдвэр гаргах	Асуудал нь хуулийн зохицуулалтаас үүдэлтэй бөгөөд захиргааны шийдвэр замаар шийдвэрлэгдэхгүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
Хууль тогтоомжийн тесэл боловсруулах	Төрийн аудитын талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг батлах тухай УИХ-ын тогтоолын тесэл боловсруулснаар төрийн аудитын байгууллагыг бэхжүүлэх, төр, засгийн газрын байгууллага, олон нийтийн оролцоог хангах замаар улс орны эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах зорилгод хүрнэ.	Улсын төсөвт нэмэлт зардал нэмэгдэнэ. Бодлогын баримт бичгийг боловсруулж батлуулснаар харилцагч талуудын хамтын ажиллагааг өргөжүүлж, мэдлэг чадвартай аудитор бэлтгэх тогтолцоо бий болгох замаар аудитын чанар, үр өгөөж дээшилнэ.	Үр дүнтэй.

## ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Төрийн аудитын талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн теслийг 1. Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө; 2. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэхийг энэ хэсгээр нарийвчлан судаллаа.

5.1. Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;

### 5.1.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Төрийн аудитын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлж хяналттай, хариуцлагатай, аудитын тогтолцоог бий болгосноор нийгэмд үзүүлж байгаа үр нөлөө, үр өгөөжийг нэмэгдүүлж, аудитад итгэх иргэдийн итгэл нэмэгдэнэ.

### 5.1.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Төрийн аудитын байгууллага нь гүйцэтгэх засаглалыг илүү сайн ажиллах явдлыг хангаж өгөх ба төсвийн хөрөнгө үр ашигтай зарцуулагдаж байгааг хянахад чухал үүрэг гүйцэтгэнэ.

Өөрөөр хэлбэр төрийн өмч, хөрөнгийг зөв зохистой, үр ашигтай ашиглах, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулах, төрийн байгууллага, олон нийтэд үнэн зөв, бодитой тайланг хүргэх нь улс орны хөгжил, нийгмийн тэгш байдал, хүртээмжтэй өсөлтөд чухал ач холбогдолтой билээ.

### 5.1.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Төрийн аудитын үйл ажиллагаа нь нийгмийн бүхий л салбарт хүрч ажилладаг бөгөөд төсөв санхүүгийн хувьд үр ашигтай зарцуулж байгаа эсэхийг хянахаас гадна нөөцөө арвич хямгач, үр ашиг, үр нөлөөтэй ашиглаж байгаа эсэх, үйл ажиллагаандаа хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актаар тогтоосон шаардлагыг сахин биелүүлж байгаа байдлыг шалгаж дүгнэлт, зөвлөмж гаргаж, хэрэгжилтийг тооцож ажилласнаар нийгэмд үзүүлэх үр нөлөөг нэмэгдүүлж байна.

### 5.1.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Төрийн аудитын талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг батлагдан гарч хэрэгжсэнээр байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

6.1. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх;

Монгол Улсад хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм бий болгох Үндсэн хуулийн эрхэм зорилго болон “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”, Төрийн аудитын тухай хууль тогтоомжид нийцэж байгаа болно.

## ЗУРГАА. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Төрийн аудитын талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн төслийг боловсруулах хувилбарыг шалгуур үзүүлэлтийн дагуу дараах байдаар дүгнэв:

№	Шалгуур үзүүлэлт	Зохицуулалтын хувилбар: Төрийн аудитын талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах
1	Зорилгод хүрэх байдал	Төрийн аудитын талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг батлах тухай УИХ-ын тогтоолын төсөл

		боловсруулснаар төрийн аудитын байгууллагыг бэжжүүлэх, төр, засгийн газрын байгууллага, олон нийтийн оролцоог хангах замаар улс орны эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах зорилгод хүрнэ.
2	Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө	<p>Төрийн аудитын байгууллага нь гүйцэтгэх засаглалыг илүү сайн ажиллах явдлыг хангаж өгөх ба төсвийн хөрөнгө үр ашигтай зарцуулагдаж байгааг хянахад чухал үүрэг гүйцэтгэнэ.</p> <p>Төрийн аудитын үйл ажиллагаа нь нийгмийн бүхий л салбарт хүрч ажилладаг бөгөөд төсөв санхүүгийн хувьд үр ашигтай зарцуулж байгаа эсэхийг хянахаас гадна нөөцөө арвич хямгач, үр ашиг, үр нөлөөтэй ашиглаж байгаа эсэх, үйл ажиллагаандаа хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актаар тогтоосон шаардлагыг сахин биелүүлж байгаа байдлыг шалгаж дүгнэлт, зөвлөмж гаргаж, хэрэгжилтийг тооцож ажилласнаар нийгэмд үзүүлэх үр нөлөөг нэмэгдүүлж байна.</p>
3	Зардал үр өгөөжийн харьцаа	Улсын төсөвт нэмэлт зардал нэмэгдэнэ. Бодлогын баримт бичгийг боловсруулж батлуулснаар харилцагч талуудын хамтын ажиллагааг өргөжүүлж, мэдлэг чадвартай аудитор бэлтгэх тогтолцоо бий болгох замаар аудитын чанар, үр өгөөж дээшилнэ.
4	Гарч болох сөрөг үр дагаврыг илрүүлэх	Байхгүй
5	Хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх	Нийцэж байгаа
6	Тухайн зохицуулалтаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх этгээдийг тогтоох	Төрийн аудитын байгууллагын аудитор, шинжээч болон хувийн аудитын хуулийн этгээдийн аудитор, Засгийн газрын дотоод аудитор

## **ДОЛОО. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ**

Төрийн аудитын байгууллагын хөгжлийн бодлого нь улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд шууд нөлөөлдөг, бизнесийн таатай орчныг бий болгож, төрийн секторын менежментийг сайжруулах, төрийн секторт өндөр стандарт тогтооход чухал ач холбогдолтой.

Даяаршил, техник, технологийн үсрэнгүй хөгжил, мэдээллийн эрин үеийн нөлөөллөөр хүний амьдралын хэв маяг хурдацтай өөрчлөгдж, энэ нь төрийн байгууллагын хөгжилд бодитоор нөлөөлөх боллоо.

Ардчилсан төртэй улс орнуудад парламентын хяналт нилээд чухал байр суурийг эзэлдэг байна. Парламент нь төрийн эрх барих дээд байгууллагын хувьд хууль тогтоох эрх мэдлийг хадгалан хууль эрх зүйн хяналт, төрийн үндсэн бодлогын шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавих, төрийн санхүү зээл, татвар мөнгөний бодлого, улсын төсөв, улсын эдийн засгийн хөгжлийн үйл явцад хяналт тавих үүрэгтэй байдаг.

Төрийн аудитын талаар төрөөс баримтлах бодлогын судалгааны ажлын хүрээнд төрийн аудитын байгууллагуудын олон улсын тэргүүн туршлагыг судалж, манай нөхцөлд ашиглах боломжтойг нь энэхүү тайлангаар санал болгохыг зорьсон болно.

Төрийн аудитын талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн судалгаанд төрийн аудитын байгууллагын хөгжлийн олон улсын чиг хандлагыг тодорхойлохдоо Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага (ИНТОСАИ)-ийн “Стратеги төлөвлөгөө 2017-2022”, “ИНТОСАИ Хөгжлийн санаачлага” стратеги төлөвлөгөө 2014-2018, Аудитын дээд байгууллагуудын Азийн байгууллага (ACOSAI)-ын Стратеги төлөвлөгөө 2016-2021 болон аудитын хөгжлөөрөө дэлхийд тэргүүлэгч Норвеги, Шинэ-Зеланд, Австрали, Их Британи, Умард Ирландын нэгдсэн вант улс зэрэг Монгол Улстай адил Вестминистерийн тогтолцоотой улс орнуудын аудитын дээд байгууллагуудын бодлогын баримт бичгүүдийг судлав.

### **ИНТОСАИ буюу Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага**

ИНТОСАИ 1953 онд Кубын Хавана хотод 34 аудитын байгууллага үүсгэн байгуулсан бөгөөд 2010 оны байдлаар нийтдээ 193 гишүүн байгууллагуудыг эгнээндээ нэгтгэжээ. Үнэт зүйлс нь хараат бус байдал, нэгдмэл байдал, мэргэжлийн ур чадвар, найдвартай байдал, хүртээмжтэй байдал, шинэтгэл.

ИНТОСАИ нь алсын хараа, зорилго, зорилтоо оновчтой тодорхойлсноор бусад уялдаа холбоо бүхий байгууллагууд, олон улсын иргэний нийгмийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа эрчимжүүлж, тогтвортой ажиллах боломжтой болох юм.

2016 оны 12-р сард АНЭУ-ын Абу Даби хотноо зохион байгуулгдсан ИНТОСАИ-н Конгрессийн хурлаар энэхүү Стратеги төлөвлөгөө батлагдсан ба дараах үндсэн 2 зүйлийг авч үзсэн. Үүнд:

а) Тогтвортой Хөгжлийн Зорилгууд: ИНТОСАИ нь 2030 оны Тогтвортой Хөгжлийн Үзэл баримтлалд авлигын эсрэг тэмцэх сайн засаглалыг улс орнуудад бэхжүүлэхэд хэрхэн хувь нэмрээ оруулах;

б) Мэргэшсэн байдал: ИНТОСАИ нь байнгын үйл ажиллагаатай олон улсын байгууллага болоход ямар итгэл үнэмшил, найдвартай байдлыг бий болгох шаардлагатайд

ИНТОСАИ-н Конгрессоос стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх үүрэг, оролцоог шинэчлэн баталж уг байгууллага үр ашигтай, өгөөжтэй, тэнцвэртэй, ил тод үйл ажиллагаагаа эрхлэх боломжийг тодорхой болгож өгсөн. ИНТОСАИ нь үйл ажиллагаанд шаардлагатай санхүүгээ тодорхой дүрэм журамд тусгах тухайн цаг үеэс шалтгаалсан бодитой зарцуулалтаяа хийх тухай тусгайлан зааж өгчээ.

Конгрессоос олгосон эрх үүрэг нь уг төлөвлөгөөг үр ашигтай хэрэгжүүлэх, ИНТОСАИ болон түүний гишүүдэд үр ашигтай, өгөөжтэй, хариуцлагатай, ил тод үйл ажиллагаа явуулах нь улс орон өмнөө тавьсан зорилтдоо хүрэх мөн олон улсын хэмжээнд баталсан хөгжлийн зорилгодоо хүрэх таатай нөхцөлийг бүрдүүлсэн.

ИНТОСАИ-н дунд хугацааны "Стратеги төлөвлөгөө 2017-2022"-д дөрвөн зорилго тусгагдсан ба эдгээр нь 1. Мэргэжлийн стандарт, 2. Чадамжийн хөгжил, 3. Мэдлэгийн үйлчилгээ 4. АДБ-ын үнэ цэнийг олон улсын байгууллагын хувьд дээд хэмжээнд хүргэх явдал болно.

АДБОУБ дээрх дөрвөн зорилгоос гадна ирэх жилүүдэд дараах таван тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхээр тодорхойлоод байна. Эдгээр нь:

АДБ-ын бие даасан хараат бус байдлыг хангаж, дэмжих;

Үндэстэн бүр тогтвортой хөгжлийн хүчин чармайлтын хүрээнд Тогтвортой хөгжлийн зорилтыг нягтлах, арга хэмжээ авахад хувь нэмэр оруулах;

Үр дүнтэй хөгжил, хамтын ажиллагааны оновчтой зохион байгуулалт, мэдлэгээ хуваалцах зэрэг нь АДБ-ын үр ашиг, гүйцэтгэлийг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ.

Стратегид чиглэсэн, шуурхай ИНТОСАИ-г бий болгосноор олон улсад хурдацтай өрнөж буй боломж эсвэл эрсдэлийн эсрэг хариу үйлдэл үзүүлэх боломжтой болно.

ИНТОСАИ-н бүс нутгийн байгууллагууд хоорондын мэргэжил, хамтын ажиллагааны уялдаа холбоог сайжруулах зэрэг болно.

Урт хугацааны санхүүгийн бодлогын тогтвортой байдал нь үндэсний сайн засаглалын чухал хэсэг гэдэг нь маргашгүй билээ<sup>3</sup>.

АДБ-ууд өөрсдийн улс орны Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрх, чиг үргийнхээ хүрээнд хамгийн үр ашигтай гэж үзсэн аргаар аудитыг зохион байгуулна.

<sup>3</sup> Beijing Declaration on Promotion of Good Governance 2013

Сайн зохион байгуулалттай аудитын дээд байгууллага нь Засгийн Газар илүү сайн ажиллах явдлыг хангаж өгөх ба хөрөнгө үр ашигтай зарцуулагдаж байгааг хянахад чухал үүрэг гүйцэтгэнэ.

Нийтийн хөрөнгө, мөнгө зөв зарцуулагдаж байгааг батлах нь үндэсний хөгжилд хувь нэмэр оруулаад зогсохгүй бас ядуурлыг бууруулахад чухал ач холбогдолтой. Гэвч олон улс орнуудын АДБ-уудын хараат бус байдал нь бүрэн баталгаажаагүй, Засгийн Газар, Парламент, иргэд, хэвлэл мэдээлэл, хөгжлийн түншлэлийн эх үүсвэр, ур чадвар дутагдалтай байна.<sup>4</sup>

Аудитын дээд байгууллагын хараат бус байдлын тухай Мексикийн тунхаглалын дагуу Аудитын дээд байгууллагууд зохистой хамгаалалтыг нэмэгдүүлж, тэдний хараат бус байдалд тулгарах бодит болон болзошгүй бэрхшээлийг арилгах замаар өөрсдийн үнэ цэнийг хамгаалах ёстой.

#### ИНТОСАИ-Н ХӨГЖЛИЙН САНААЧЛАГА буюу АИ ДИ АИ

АИ ДИ АИ нь 1986 онд ИНТОСАИ-ын тогтоол шийдвэрээр үүсгэн байгуулагдаж, 1986-2000 оны хооронд Канадын АДБ-ын дэмжлэгтэйгээр зохион байгуулагдсан болно.

Мөн 1998 онд ИНТОСАИ-н XVI хурлын үеэр, Ерөнхий Ассамблейн шийдвэрээр АИ ДИ АИ-ийн нарийн бичгийн дарга нарын газрыг Канадаас Норвеги улс руу 2001 оны 01 сарын 01-ний дотор шилжүүлэхийг зөвшөөрчээ.

Норвеги улсад АИ ДИ АИ-ийг байгуулах хүсэлтийг Норвегийн Ерөнхий Аудиторын газраас (OAGN) гаргасан саналыг үндэслэн 1998 оны 10-р сарын 29-нд Норвегийн Засгийн Газраас гаргасан шийдвэрээр батлуулсан байна.

Норвегийн Засгийн Газар (Гадаад хэргийн яам) нь Олон улсын хөгжлийн хамтын үйл ажиллагааны төсөвт жил бүр буцалтгүй тусlamж үзүүлэх тухай болон АИ ДИ АИ-ийн Нарийн бичгийн дарга нарийн газрын урт удаан хугацааны санхүүгийн тогтвортой үйл ажиллагааг дэмжсэн зэрэг нь Норвегийн Ерөнхий Аудиторын газрыг АИ ДИ АИ-ийг зохион байгуулах чухал урьдчилсан нөхцөл болсон юм.

1986 онд байгуулагдсан цагаасаа хойш АИ ДИ АИ нь чадавхыг бэхжүүлэх дэлхийн хэмжээний хүчин чармайлтыг нэгтгэх, хоёр талт болон олон талт хамтын ажиллагааны тогтолцоог хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэжээ. Хөгжиж буй орнууд болон хамгийн буурай хөгжилтэй орнуудад АДБ-уудын чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, Чадавхыг бэхжүүлэх төслийн саналыг санхүүгийн тогтвортой дэмжлэгээр хангах, алсын хараатай чиг үүргийг хэвшүүлэх, чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн мэдээллийн технологийн аргачлалыг ашиглах, түгээн дэлгэрүүлэх зэрэг чухал үүргүүдийг гүйцэтгэсээр ирэв.

Өнгөрсөн 27 жилийн хугацаанд зөвшилцөлд хүрэх, мэдлэг, туршлага солилцоход дэмжлэг үзүүлэх зорилгоор АИ ДИ АИ нь АДБ-уудын мэргэжлийн болон институцийг чадавхжуулах, чадавхыг бэхжүүлэхэд чиглэгдсэн хөтөлбөрийг дэмжих, Чадавхыг бэхжүүлэх хүчин чармайлтыг зохицуулах, тогтвортой сургалтын механизмыг бий болгох. Үүнд ISSAI Implementation Initiative – the 3i Programme, the e-Learning course on Risk Based Approach to Financial Auditing (RBAFA) зэрэг олон

<sup>4</sup> OECD, Good Practices in Supporting Supreme Audit Institutions

хөтөлбөрийг бэлтгэж, бие даасан, чадварлаг, мэргэжлийн аудиторуудыг сургахад АДБ-уудад тусалж ирсэн.

Олон нийтийн итгэл үнэмшил, хараат бус байдал, ил тод байдал, хариуцлагын тогтолцоо, шударга ёс мөн АДБ-ын бусад үндсэн үнэт зүйлсэд итгэх, итгэл үнэмшлийг хэрхэн хангах, улсын салбарын үлдсэн хэсэгт үлгэр жишээ үзүүлэх зорилгоор төрийн санхүүжилтийг хамгаалагч болох зэргээр улс орны засаглалын механизмын чухал тулгуур болж үйлчлэх;

**АИ ДИ АИ-ийн үйлчилгээ түгээх загвар: Түншлэлийн загвар, үйлчилгээ үзүүлэх хандлагууд, нөөц болон санхүүжилт, үндсэн зарчмууд**

**АИ ДИ АИ-ийн чадавхыг хөгжүүлэх загвар: АИ ДИ АИ-ийн чадавх: үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад АИ ДИ АИ-д ямар чадавх хэрэгтэй вэ?**

- IC1. Сайн засаглал;
- IC2. Нөөцийн үр ашигтай менежмент;
- IC3. Мэргэжлийн баг;
- IC4. Харилцагч талуудын харилцаа, хамтын ажиллагаа;

**АИ ДИ АИ-ийн үндсэн зарчмууд**

- АДБ-ын хэрэгцээнд нийцсэн байх;
- Чадавхийн хөгжлийн үйл ажиллагааг дэмжих;
- Үр шимиийг хүртэгч АДБ-уудад эрх олгох;
- Түншлэлийг бий болгох;
- Өөртөө хариуцлага хүлээх;

**АДБ-ийн гүйцэтгэл болон чадавхыг бэхжүүлэх түншлэлийн загвар**

АИ ДИ АИ нь АДБ-ийн үйл ажиллагааны гүйцэтгэл болон чадавхд шууд дэмжлэг үзүүлэх чиглэлийг эрэлхийлэх. Тухайлбал, 1) харилцагч талуудаар дамжуулан чадавхыг хөгжүүлэх хөтөлбөрүүдээр шууд хангах, мөн 2) АДБ-ын чадавх, түвшинг сайжруулахад хамтрагч талуудын хүчин чармайлтыг дэмжих болон бэхжүүлэх;

АИ ДИ АИ нь дэлхийн түвшинд хөгжиж буй орнуудад АДБ-аар дамжуулан хэрэгцээнд суурилсан үр дүнтэй болон тогтвортой чадавх хөгжүүлэх зорилtot хөтөлбөрүүдээр хангадаг ба эдгээр хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхдээ ИНТОСАИ-ийн зөвлөл, ажлын хэсэг, бүсийн ИНТОСАИ хороод болон бусад сонирхогч талуудын оролцоотой явуулна.

**АСОСАИ буюу Аудитын дээд байгууллагуудын Азиин байгууллагыг**

АСОСАИ-г 1979 онд 11 гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр үүсгэн байгуулсан. Гишүүдийн бүрэлдэхүүн нь үүсгэн байгуулагчид, гишүүд болон хамтрагчдаас бүрддэг. Одоогийн байдлаар 46 улсын АДБ гишүүн болсон.

АСОСАИ стратеги төлөвлөгөө нь 2016-2021 АСОСАИ-н гурван стратегийн зорилт, дөрвөн үнэт зүйлсийг тодорхойлсон. Стратегийн төлөвлөгөөг амжилттай

хэрэгжүүлж хяналт тавих зорилгоор анх удаа зорилт тус бүр дээр Гүйцэтгэлийн чухал үзүүлэлтийг тодорхойлсон .

Энэхүү төлөвлөгөө нь АСОСАИ-г аудитын салбарт төдийгүй дэлхийд жишиг болсон нийгэмлэг болоход чухал ач холбогдолтой.

2016-2021 стратегийн төлөвлөгөө нь гурван стратегийн зорилтыг тавьсан. Үүнд: 1. Гишүүн АДБ-уудын чадавхыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх; 2. Гишүүн АДБ-уудын хооронд мэдлэг солилцох үйл ажиллагааг сайжруулах; 3. Бүсийн ажлын хэсгийн загвар гаргах.

Эдгээр зорилтууд нь өмнөх төлөвлөгөөний зорилтуудтай адил санагдаж болох ч энэ стратегийн төлөвлөгөөнд шинэ онцлог чанаруудыг тусгаснаараа давуу талтай. Нэгдүгээрт тус төлөвлөгөөнд эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс болон зорилтуудын талаар дэлгэрэнгүй тайлбарыг оруулсан. Хоёрдугаарт үйл ажиллагаа, үр дүн, хугацаа, төсөв болон эрсдэлийг тусгасан Хэрэгжилтийн матриксийг харуулсан. Энэхүү төлөвлөгөө нь Нөөцийн төлөвлөгөөнд тусгасан төсвийн дагуу боловсруулсан гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Гуравдугаарт стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хэсгийг томилох бөгөөд гүйцэтгэлийг хэмжих бүдүүвчийг багтаасан. Дөрөвдүгээрт 1 болон 2-р зорилтуудын хүрээнд чадавхыг хөгжүүлэх үйл ажиллагааг Чадавх хөгжүүлэх комиссын болон Чадавх хөгжүүлэх удирдах ажилчдын үүрэг хариуцлага болгохоор тооцоолжээ.

АСОСАИ-н эрхэм зорилго нь гишүүн АДБ-уудын гүйцэтгэлийг өндөр түвшинд хүрэх үндсийг тавьж өгөх юм. Энэхүү зорилгод хүрэх гол багана нь чадавхыг хөгжүүлэх болон мэдлэг солилцох гэдгийг стратегийн төлөвлөгөөтэй танилцсан хүн бүр ойлгох болно.

АСОСАИ-н сургалт, дадлагын мэргэжилтнүүд АСОСАИ-н сургалтаас гадна гишүүн АДБ-уудын сургалтыг амжилттай хэрэгжүүлж байна. Сургалтын мэргэжилтнүүд болон зохион байгуулагч нарыг цаашид хөгжүүлж мэдлэг, чадварыг нь сайжруулах хэрэгтэй. Ирээдүйн хэрэгцээн дээр тулгуурлан АИ ДИ АИ-ийн санаачилсан мэргэжилтнүүдийн цахим нөөцийг бий болгохыг бид дэмжиж байна.

2016-2021 стратегийн төлөвлөгөө нь гишүүдийнхээ чадавхыг улам хөгжүүлэх, тэдний эрэлт хэрэгцээнд нийцсэн өөрчлөлт шинэчлэлтийг нэвтрүүлсэн. Өндөр чанарын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд энэхүү стратегийн төлөвлөгөө нь чухал дэмжлэг болно гэдэгт бид итгэлтэй байна. Гэсэн хэдий ч бид зөвхөн стратегийн төлөвлөгөөтэй болсондоо сэтгэл хангалиун байж болохгүй. Энэ бол зөвхөн эхлэх цэг.

Эрхэм зорилго- АСОСАИ нь ИНТОСАИ-н бүс нутгийн ажлын хэсэг бөгөөд улс төрийн бус мэргэжлийн байгууллага юм. Чадавх хөгжүүлэх, аудитын салбарт мэдлэг, туршлага солилцох арга замаар АСОСАИ нь гишүүн АДБ-ууддаа гүйцэтгэлийн өндөр түвшинд хүрэхэд дэмжлэг үзүүлдэг бөгөөд ингэснээр бусад улсын тогтвортой хөгжлийг дэмжихээс гадна ИНТОСАИ-г хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулдаг.

Үнэт зүйлс нь стратегийн төлөвлөгөөний үндсэн зарчим юм. Стратегийн төлөвлөгөөнд тусгасан зорилт, хөтөлбөр, үйл ажиллагаа тус бүр эдгээр үнэт зүйлстэй зохицсон байхаар боловсруулсан. АСОСАИ-н ирээдүйн бүх бодлого, дүрэм журмууд мөн тус үнэт зүйлстэй тохирсон байна. АСОСАИ-н үнэт зүйлс нь

мэргэжлийн ур чадвар, хамтын ажиллагаа, бусдыг хамрах, шинийг санаачлахад оршино.

Мэргэжлийн ур чадвар- АСОСАИ нь шударга, ил тод, бие даасан байдлаар ажилладаг. АСОСАИ нь ажлыг стандарт, шилдэг практикт нийцүүлж өндөр түвшинд гүйцэтгэдэг бөгөөд ирээдүйд тогтмол сайжрахаар зорилт тавьсан.

Хамтын ажиллагаа- АСОСАИ нь харилцагч талуудтай стратегийн харилцаа, түншлэл тогтоож, харилцан ашигтай хамтран ажилладаг.

Хүртээмжтэй байдал- АСОСАИ нь гишүүдийнхээ онцлог байдлыг мэддэг бөгөөд бие биенээ хүндлэх, хүйсийн тэгш харьцааг баримталдаг. Бид гишүүддээ дэмжлэг үзүүлж адил боломжийг олгодог.

АСОСАИ нь харилцагч талуудын эрэлт хэрэгцээнд тохирсон шинэ санааг нэвтрүүлэх арга замыг үргэлж хайж байдаг. Шинэ санааг туршихын тулд зөвшөөрч болохуйц эрсдлийг хийж асуудлыг шийдвэрлэх болон өөрчлөлтөд дасан зохицох чадвартай уян хатан байхыг эрмэлздэг. Гишүүддээ илүү их дэмжлэг үзүүлэх үүднээс АСОСАИ нь байгууллагын болон мэргэжилтнүүдийнхээ чадавхыг хөгжүүлэхэд илүү цогц дэмжлэг үзүүлэхээр төлөвлөж байна.

АСОСАИ нь гишүүдийнхээ хүсэлт шаардлага дээр төвлөрч ажилласаар байх болно. Чадавх дээшлүүлэх хөтөлбөрийн сэдвүүдийг гол харилцагч талуудаас авсан санал асуулга, ярилцлагын дагуу сонгоно.

Чадавх дээшлүүлэх тал дээр ИНТОСАИ болон АИ ДИ АИ-тай хамтран ажиллах- Стратегийн төлөвлөгөө нь 6 гүйцэтгэлийн үзүүлэлтийг харуулсан бөгөөд эдгээр үзүүлэлтуудээр төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх боломжтой юм. Тус үзүүлэлтүүд нь чадавх хөгжүүлэх болон мэдлэг солилцох гэсэн зорилтууд дээр төвлөрсөн бөгөөд эдгээр зорилтууд нь АСОСАИ-н стратегийн идэвхи зүтгэлийг хэмжих учир гадагшаа чиглэсэн тус хоёр зорилт дээр анхаарсан. АСОСАИ нь үзүүлэлт тус бүр дээр үндсэн мэдээлэл цуглуулах, зорилтот түвшинг тодорхойлох, тайлاغнах, гүйцэтгэлийг хэмжих системийг боловсруулна.

### *Австралийн Үндэсний аудитын газар*

Австралийн Үндэсний аудитын газрын зорилго бол Парламент, гүйцэтгэх, засаглал, олон нийтэд хараат бусаар тайлагнах замаар төрийн секторын гүйцэтгэлийг сайжруулах, Австралийн Засгийн Газрын секторын ил тод, хариуцлагатай байдлыг дэмжих явдал юм. Австралийн ҮАГ-ын алсын хараа нь “төрийн секторт хараат бусаар аудит болон холбогдох үйлчилгээгээр хангах олон улсад тэргүүлэгч болох”

Ерөнхий Аудитор нь Австралийн Парламентийн хараат бус ажилтан ба 1997 оны Ерөнхий Аудиторын тухай хуульд зааснаар Австралийн Засгийн газрын байгууллагуудад санхүүгийн болон гүйцэтгэлийн аудит хийнэ.

Нийтийн Засаглал, гүйцэтгэл, хариуцлагын тухай хууль (Public Governance, Performance and Accountability Act, 2013)-ийн ҮАГ корпорацийн төлөвлөгөө боловсруулах шаардлагатай байдаг. Орчны өөрчлөлтийг таамаглаж, түүнд хариулт өгөх чадвар бол бид ирээдүйд амжилт олоход чухал юм.

Австралийн ҮАГ-ийн стратеги чиглэл дөрвөн үндсэн хэсэг (Key Focus Area)-т тулгуурлагдана. Эдгээр нь:

1. Төрийн секторын байгууллагын гүйцэтгэлийг сайжруулахад туслахдаа Парламент болон байнгын хороодтой хараат бус, хариуцлагатай харилцах;
2. Үнэт зүйлсийг нэмсэн аудитын үйлчилгээ үзүүлэх;
3. Дэлхийн түвшний үйлчилгээ хүргэх бидний чадавхыг дэмждэг ажлын бүтээлч, хамтаж орчинг хэвээр хадгалах;
4. Бид мөнгөний үнэ цэнийг төлөөлөх үйлчилгээ үзүүлэхдээ итгэлтэй байгаа эсэх;

Австралийн УАГ-ын Корпорацийн төлөвлөгөө нь гүйцэтгэлийн хэмжүүрийн хүрээ бөгөөд энэ нь УАГ-ын бий болгосон үнэт зүйлс дээр аудит хийдэг төрийн секторын байгууллагууд, мөн Засгийн Газар болон нийгмийн хуваалцдаг үнэт зүйлсийн нийлбэр болсон нийгмийн үнэт зүйлсийг хэмжихэд сууринлагдана. Энэ төлөвлөгөө нь ирээдүйд зорилгодоо хүрэх чадварыг тасралтгүй хөгжүүлэх хэрэгцээг тусгасан.

Чадавхыг хөгжүүлэх хүрээнд дараах стратегиуд байна.

- Олон улсын ажил хэрэг,
- Чанар,
- Харилцаа, холбоо
- Ажилтнууд ба байгууллагын чадавх
- Мэдээллийн технологи

*Их Британи, Умард Ирландын нэгдсэн Вант улсын Үндэсний аудитын газар*

Английн Үндэсний аудитын газар нь төр, Засгийн Газрын байгууллагуудад аудит хийх үүрэгтэй хараат бус, Парламентийн байгууллага билээ. Английн УАГ-ын алсын хараа нь “Үндэстэндээ мөнгийг ухаалгаар зарцуулахад туслах явдал” бөгөөд зорилт нь (i) мэдлэгээ хөгжүүлж, ашиглах, (ii) нөлөөллөө нэмэгдүүлэх (iii) дээд зэргийн гүйцэтгэл үзүүлэх юм.

УАГ-ын тэргүүн нь Ерөнхий Аудитор бөгөөд төлөөлөгчдийн танхимын ажилтан бөгөөд энэ нь Хатан хааны томилдог албан тушаалтан юм. Үнэт зүйлс- Хараат бус байдал, Итгэл хүлээсэн байдал, Хамтын ажиллагаа, Шударга байдал, Хязгаарлагдмал нөөцөөр төрийн үйлчилгээ үзүүлэх, Төрийн үйлчилгээг илүү сайн хүргэхийн тулд Засгийн газар өгөгдөл, технологи ашиглах явдал юм.

УАГ нь төрийн үйлчилгээг сайжруулах замаар Парламентад дэмжлэг үзүүлдэг ба Засгийн газрын агентлагууд, яамдууд болон бусад байгууллагуудын санхүүгийн Тайланд аудит хийж үр дүнг нь Парламентад тайлагнадаг.

Английн үндэсний аудитын газрын стратеги нь 2017-2018, 2019-2020 онуудыг хамрах ба УАГ-ын газрын үүрэг роль, шинэ сорилтууд, сорилтуудтай тулах нь, эх үүсвэр, бид хэрхэн хувь нэмэр оруулдаг вэ гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

Төрийн үйлчилгээ нь бага зардлаар оновчтой үйлчилгээ үзүүлэх явдал бөгөөд санхүүжилтийн хязгаарлалт нь мөнгөний үнэ цэнийн хувьд эрсдэл бий болгож

байна. Парламентад нийтийн хөрөнгөнд хариуцлага тооцох хүчтэй аудитын байгууллага хэрэгтэй.

Тиймээс Парламент болон Засгийн Газар УАГ-ын үүрэг ролийг тасралтгүй нэмэгдүүлж байгаа ба Network Rail, UK Asset Resolution зэрэг байгууллагад аудит хийлгэхээр болж байгаа ба Bank of England (Английн төв банк)-д шинээр гүйцэтгэлийн аудит хийхээр болжээ.

Засгийн Газар олон нийтийн хүлээлтэд нийцсэн төрийн үйлчилгээг хязгаарлагдмал нөөцөөр үзүүлэх бөгөөд нийтийн үйлчилгээнд шинэ ур чадвар, ажлын өөр арга барилыг нэвтрүүлснээр энэ зорилгод хүрнэ гэж үздэг.

Технологи нь үр ашигтай, хэрэглэгч төвтэй үйлчилгээг үзүүлдэг хэдий ч нөгөө талаас үйлчилгээ зогсох, мөнгөн хөрөнгө алдагдах зэрэг эрсдэлийг бий болгоно. Мөн их хэмжээний өгөгдөл олж авах боломжтой байдал нь илүү мэдээлэлтэй байхыг, нотлох баримтад сууринсан шийдвэр гаргах үйл явцыг дэмждэг.

Үр нөлөөтэй харилцаа холбоо бол аливаа чадавхыг хөгжүүлэх хөтөлбөрийн хамгийн чухал хүчин зүйл юм. Энэхүү харилцааны бодлого нь харилцагч талуудтай харилцах үйл ажиллагаатай холбоотой харилцааны нөхцөл байдлыг албан ёсны болгох ба энэ нь АДБ-ын үйл ажиллагааг жигдруүлж, харилцагчидтай үр нөлөөтэй харилцах хэрэгцээ шаардлага нь үйл ажиллагааг илүү зохион байгуулалттай болгоно.

### *Норвегийн Ерөнхий аудиторын газар*

Норвегийн Ерөнхий аудиторын газар (Riksrevisjonen) нь Норвегийн сайн засаглал, авилгын эсрэг бодлогын хэрэгжилтийг хангаж, төрийн албыг хянадаг үндсэн байгууллага юм.

Норвеги улс нь сайн засаглалыг бэхжүүлэх, авилгатай тэмцэх асуудалд онцгой ач холбогдол өгч, авлигын эсрэг бодлогыг олон улсын хэмжээнд явуулдаг бөгөөд авлигатай тэмцэхийн тулд нээлттэй, хариуцлагын тогтолцоог бий болгоход төрийн болон хувийн хэвшил адилхан үүрэг хүлээх ёстой. Ил тод байдал, итгэл хүлээх чадвар нь тухайн улсын нэр хүндийг илтгэх чухал хэмжүүр гэж үздэг.

Норвегийн Ерөнхий аудиторын газрын эрхэм зорилго нь нийтийн хөрөнгийн хэрэглээг сайжруулах.

Нэр хүндийн үнэт зүйлс-Өрсөлдөх чадвар, хараат бус байдал, зорилго

Норвегийн аудитын байгууллага ямар нэг маргаантай асуудлаар хэвлэл мэдээлэлд ярилцлага өгөхгүй байх, хараат бус байдлыг байгууллагын түвшинд авч үзэх төдийгүй хувь хүний түвшинд авч үзэж байна.

2014-2018 оны стратеги төлөвлөгөөнд "Сайн нэрийг хадгалах нь сайн мэргэшсэн ажилтнуудаас шалтгаална (To maintain a good reputation, we are dependent on highly qualified employees)"

Хамтын ажиллагааны үнэт зүйлс- багийн оюун санаа, нээлттэй байдал, хүндлэл

Норвегийн Ерөнхий аудиторын газар нь хүчтэй сайн засаглалыг бий болгож, институцийн үр дүнтэй бодлого хэрэгжүүлснээр тогтвортой хөгжлийг бий болгож

чадсан. Өөрөөр хэлбэл институцийн чанар эдийн засгийн бодлого, эрдэс баялгийн менежментийн чанарт нөлөөлж байна. Нийтийн хөрөнгөнд үзүүлэх сөргө нөлөөллийг хүчтэй ТАБ үгүй хийнэ.

Хамгийн чухал зүйл бол бодлого болон практик үйл ажиллагаа нь эдийн засгийн өсөлтийн үр шимийг хуваарилахад нөлөөлдөг нийтийн болон хувийн секторын хоёулангийнх нь институцийг бэхжүүлэх явдал юм.

Энэ судалгааны зорилгоор чадавх гэдгийг “төрийн байгууллагаас оролцогч талуудтай хамтран өөрийн үүрэг хариуцлагыг үр дүнтэй, үр ашигтай хэрэгжүүлэх чадвар” гэж тодорхойлов.

Энэ нь бодлого болон төрийн байгууллагуудын зохион байгуулалт, төлөвлөлт болон бодлого хамгийн үр ашигтай байхаар боловсруулах боломж бүхий бүтэц зохион байгуулалтыг хийж чадсан эсэх юм.

## НАЙМ. ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Аудитын дээд байгууллага нь Үндэсний аудитын газар бөгөөд ИНТОСАИ, АСОСАИ, ИНТОСАИ-н хөгжлийн санаачилга зэрэг аудитын дээд байгууллагуудын гишүүнчлэлтэй бөгөөд бусад улс орнуудын аудитын дээд байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна.

Төрийн аудитын байгууллага нь хууль эрх зүйн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа хэдий ч Үндсэн хуулийн байгууллага биш, аудитын үйл ажиллагаа явуулахад зарим хууль эрх зүйн хувьд хүндрэлтэй, зөрчилтэй асуудал байгаа бөгөөд ажилтнуудын цалин хөлсний хувьд хангалттай бус хэмжээнд үйл ажиллагаа явуулж байна.

Үндэсний Аудитын Газрын 2013-2018 онд хэрэгжүүлэх стратегийн төлөвлөгөөг баталсан бөгөөд бүрэн хэмжээний хяналт үнэлгээ хийсний дараа 2018-2023 оны стратеги төлөвлөгөө боловсруулахаар ажиллаж байна.

ТАБ ажил үүргээ гүйцэтгэхэд өнөөгийн статус, хуулиар тогтоосон эрх мэдэл хангалтгүй байгаа бөгөөд хуулиар нэмж тогтоох бүрэн эрхийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд статусыг Үндсэн хуулийн байгууллага болгох шаардлагатай байна.

Төрийн аудит нь шалгагдагч байгууллагаас хараат бус, бие даасан, гадны нөлөөллөөс хамгаалагдсан, үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх нэг урьдач нөхцөл бол ТАБ-ын ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэж, цалин, хангамжийг нэмэгдүүлэх явдал юм.

Мөн төрийн аудитын байгууллагын хөгжлийн шаардлагыг хангахуйц мэдлэг, ур чадвар, хандлага бүхий хүний нөөцийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Улс орны тогтвортой хөгжилд төрийн аудитын гүйцэтгэх үүрэг өсөн нэмэгдэж байгаа өнөөгийн нөхцөлд төрийн аудитын нийгэмд оруулах үнэ цэнэ ба өгөөж, улс орны хөгжилд үзүүлэх бодит нөлөө, аудитын олон улсын хөгжлийн чиг хандлагыг харгалзан үзэж, төрийн аудитыг цаашид хөгжүүлэх бодлогыг тодорхойлох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Иймд дээрх шийдвэрлэх ёстой асуудлаа тодорхойлж, дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгах, ТАБ-ын үйл ажиллагааг олон улсын аудитын

байгууллагын хөгжлийн чиг хандлагатай нийцүүлэн, төрийн аудитын хууль, эрх зүйн орчинг оновчтой бүрдүүлж, институцийн чадавхыг сайжруулах замаар дунд хугацааны зорилгодоо хүрэх боломжтой.

## ТОВЧИЛСОН ҮГ

АДБ	Аудитын дээд байгууллага
АДБОУБ	Аудитын дээд байгууллагын Олон улсын байгууллага /ИНТОСАИ/
АДБАБ	Аудитын дээд байгууллагын Азийн байгууллага /ACOSAI/
АНУ	Америкийн нэгдсэн улс
АНЭУ	Арабын нэгдсэн эмират улс
ТАБ	Төрийн аудитын байгууллага
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ТӨРИЙН АУДИТЫН ТАЛААР ТӨРӨӨС  
БАРИМТЛАХ БОДЛОГЫН БАРИМТ  
БИЧГИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН ҮНЭЛГЭЭ

2018 он

## АГУУЛГА

УДИРТГАЛ .....	2
НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ.....	2
ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ.....	3
ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ .....	4
ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ.....	6

## УДИРТГАЛ

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 дугаар зүйлийн 5.1.22 дахь хэсэгт “Хууль зүйн судалгааны чанарыг шинэ түвшинд гаргаж, хууль тогтоомжийн боловсруулалт, хэрэгжилтийг судалгаанд суурилан хөгжүүлэх боломжийг бүрдүүлнэ”, мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-т “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах, түүнд олон нийтийн оролцоог хангах, хууль тогтоомжийн төсөлд тавих шаардлагыг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх замаар хууль дээдлэх ёсыг бэхжүүлнэ” гэж тусгасан.

Энэ хүрээнд 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн “Хууль тогтоомжийн тухай” хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ыг баталсан.

Энэхүү судалгааны зорилго нь Засгийн газраас баталсан аргачлалыг баримтлан “Төрийн аудитын талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг”-ийн төсөлд “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийхэд оршино.

Түүнчлэн энэхүү судалгаагаар “Төрийн аудитын талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг”-ийн төслийн үр нөлөөг үнэлж, уг төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах замаар төрийн аудитын эрх зүйн орчныг сайжруулах боломжийг тодорхойлох, мөн бодлогын баримт бичгийг хэрэглэхэд ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад хууль санаачлагчид дэмжлэг үзүүлэх, улмаар бодлогын баримт бичгийн төслийн чанарыг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөхийг зорилоо.

“Төрийн аудитын талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг”-ийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал” /цаашид “Аргачлал” гэх/-д заасны дагуу дараах үе шаттайгаар хийлээ. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

## НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Бодлогын баримт бичгийн төслийн үр нөлөөний үнэлгээг тооцоходоо хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс дараах 3 шалгуур үзүүлэлтийг сонголоо.

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Харилцан уялдаа

## Шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл:

### ➤ Зорилгод хүрэх байдал:

Энэхүү үнэлгээний үндсэн зорилго нь тухайн тогтоолын төслийн зохицуулалт анх дэвшүүлсэн зорилго буюу тулгамдсан бэрхшээлийг шийдвэрлэж чадах эсэхийг тогтоох билээ. Иймд тогтоолын төслийн зохицуулалт нь төслийн үзэл баримтлал буюу төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

### ➤ Практикт хэрэгжих боломж:

Тухайн хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэх, хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, санхүү болон хүний нөөцийн байдал зэргийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

### ➤ Харилцан уялдаа:

